| Банканд байгаа бэлэн мөнгө | 5,839,357.8 | 6,510,225.9 | 670,868.1 | 100.00 |
| Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө | 1,172.0 | 3,084.6 | 1,912.6 | 0.05 |
| Арилжааны банк дахь харилцах | 5,838,185.8 | 6,507,141.3 | 668,955.5 | 99.95 |
| **Дүн** | **5,839,357.8** | **6,510,225.9** | **670,868.1** | **100.00** |

*Эх сурвалж:Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 3,084.6 мянга төгрөг нь аймгийн Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, 6,507,141.3 мянган төгрөг нь арилжааны банкны дансанд байршиж байгаа үлдэгдэл байна.

*Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл сангаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Төвлөрсөн сан | 2,894.9 | 7,889.5 | 4,994.6 | 0.12 |
| Тэтгэврийн даатгалын сан | 5,614,007.4 | 6,255,480.3 | 641,472.9 | 96.09 |
| Тэтгэмжийн даатгалын сан | 162,304.4 | 211,458.5 | 49,154.2 | 3.25 |
| ҮОМШӨД-ын сан | 39,396.3 | 16,831.4 | (22,564.9) | 0.26 |
| ЭМД-ын сан | 763.7 | 183.1 | (580.6) | 0.00 |
| Ажилгүйдлийн даатгалын сан | 18,818.7 | 18,383.0 | (435.7) | 0.28 |
| **Дүн** | **5,838,185.4** | **6,510,225.8** | **672,040.4** | **100.0** |

*Эх сурвалж:Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

*Хүснэгт №3. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл сангаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Төвлөрсөн харилцах | Тэтгэвэр | Тэтгэмж | ҮОМШӨ | ЭМД | Ажилгүйдэл | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Голомт банк | - | 121,425.7 | - | - | - | - | 121,425.7 |
| ХААН банк | 4,768.7 | 3,956,406.6 | 36,505.8 | 6,831.4 | 172.9 | 10,878.7 | 4,015,563.9 |
| Төрийн банк | 26.3 | 2,177,648.0 | 174,952.8 | 10,000.0 | 0.2 | 7,504.3 | 2,370,131.5 |
| Хас банк | 10.0 | - | - | - | 10.0 | - | 20.0 |
| Төрийн сан | 3,084.6 | - | - | - | - | - | 3,084.6 |
| **Дүн** | **7,889.5** | **6,255,480.3** | **211,458.5** | **16,831.4** | **183.1** | **18,383.0** | **6,510,225.8** |

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 3,823,794.7 мянга, эцсийн үлдэгдэл 5,010,794.6 мянган төгрөг болж, 1,186,999.8 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 448,573.7 | 919,050.5 | 470,476.8 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 3,302,483.0 | 4,009,409.6 | 706,926.5 |
| Байгууллагаас авах авлага | 68,827.1 | 81,358.1 | 12,531.0 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 3,910.9 | 976.4 | (2,934.5) |
| **Дүн** | **3,823,794.7** | **5,010,794.6** | **1,186,999.8** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

**<u>Нийгмийн даатгалын сан:</u>**

Төлбөр үйлчилгээний авлага нь оны эхний үлдэгдэл 448,573.7 мянга, оны эцсийн үлдэгдэл 919,050.5 мянган төгрөг болж 470,476.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2020 оноос эхэлж дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /COVID/ цар тахлын үед аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа зогсонги, санхүүгийн чадамж буурснаар нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаанд нь төлөөгүйгээс үүсэн авлага болно.

Татаас санхүүжилтийн авлага нь 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа даатгуулагчийн ажлын байрыг хадгалах зорилгоор олгосон санхүүгийн дэмжлэгтэй холбоотой авлагын үлдэгдэл ба тайланд онд 433,994.4 мянган төгрөгийн санхүүжилт авч авлагыг бууруулан оны эцэст улсын төсвөөс авах 4,009,409.6 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Байгууллагаас авах авлага оны эхний үлдэгдэл 68,827.1 мянга, оны эцсийн үлдэгдэл 81,358.1 мянган төгрөг болж 12,531.0 мянган төгрөгөөр өссөн нь 2021 оны 12 дугаар сард сайн дурын даатгуулагч эхийн тэтгэмжийн даатгалын сангаас төлөх 12,531.0 мянган төгрөгийг данс андуурч хийснээр тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сангийн хооронд 12,531.0 мянган төгрөгийн авлага, өглөг үүссэн ба 2022 оны 03 дугаар сард данс хооронд гүйлгээ хийж залруулсан.

**<u>Нийгмийн даатгалын хэлтэс:</u>**

Хувь хүнээс авах авлагын оны эхний үлдэгдэл 3,910.9 мянган төгрөг оны эцэст 976.4 мянган төгрөг болж 2,934.5 мянган төгрөгөөр буурсан байна. Уг авлага нь тус байгууллагын даргаар ажиллаж байсан иргэнтэй холбоотой авлага ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж тайлант онд 2,934.5 мянган төгрөгийн барагдуулсан байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 15,710.1 мянга, эцсийн үлдэгдэл 17,318.6 мянган төгрөг болж, 1,608.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бичиг хэргийн материал | 446.6 | 842.0 | 395.4 |
| Аж ахуйн материал | 9,593.1 | 11,787.8 | 2,194.6 |
| Сэлбэг хэрэгсэл | 1,968.1 | 3,468.1 | 1,500.0 |
| Бусад хангамжийн материал | 3,702.3 | 1,220.8 | (2,481.6) |
| Дүн | **15,710.1** | **17,318.6** | **1,608.5** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 1,608.5 мянган төгрөгөөр өссөн нь, бичиг хэргийн материал 395.4 мянга, аж ахуйн материал 2,194.6 мянга, сэлбэг хэрэгсэл 1,500.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад хангамжийн материал 2,481.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 832,949.0 мянга, эцсийн үлдэгдэл 842,922.0 мянган төгрөг болж, 9,973.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга, байгууламж, орон сууц | 466,812.1 | 466,812.1 | - |
| Авто-тээврийн хэрэгсэл | 89,980.0 | 89,980.0 | - |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 141,764.5 | 151,737.6 | 9,973.0 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 63,466.8 | 63,466.8 | - |
| Програм хангамж | 3,700.6 | 3,700.6 | - |
| Бусад биет бус хөрөнгө | 67,225.0 | 67,225.0 | - |
| Дүн | **832,949.0** | **842,922.0** | **9,473.0** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021.03.29-ний өдрийн А/48 дугаар тушаалаар 2,705.1 мянга, 2021.12.30-ний А/178 дугаар тушаалаар 428.0 мянга, 2021.12.31-ний өдрийн А/177 дугаар тушаалаар 2,480.0 мянга, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Мэдээлэл технологийн төвөөс хуваарилалтаар 2021 оны 10 дугаар сарын 25-ний өдөр 2,860.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж тус тус шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 491,032.5 мянга эцсийн үлдэгдэл 436,215.0 мянган төгрөг болж, өмнөх оноос өр төлбөр 54,817.5 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| *Богино хугацаат өр төлбөр дүн* | 491,032.5 | 436,215.0 | (54,817.5) | 100 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | - | 100.0 | 100.0 | 0.02 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 63,153.7 | 89,477.7 | 26,324.0 | 20.51 |
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 427,878.8 | 346,637.3 | (81,241.5) | 79.46 |
| **Нийт дүн** | **491,032.5** | **436,215.0** | **(54,817.5)** | **100.0** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ажиллагсадтай холбоотой 100.0 мянга, 89,477.7 төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөг, 346,637.3 мянган төгрөгийн урьдчилж орсон орлогын үлдэгдэл байна.

Бараа үйлчилгээний зардлын өглөг нь тайлант хугацаанд сайн дурын даатгуулагч эхийн тэтгэмжийн даатгалын сангаас төлөх 12,531.0 мянган төгрөгийг данс андуурч

хийснээр тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сангийн хооронд 12,531.0 мянган төгрөгийн авлага, өглөг үүссэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Засгийн газрын байгууллага, бусад бүх шатны төсөв эхний үлдэгдэл 427,878.8 мянга, эцсийн үлдэгдэл 346,637.3 мянган төгрөг болж 81,241.5 мянган төгрөгөөр буурсан нь сайн дурын даатгуулагчийн гэрээ он дамнаж хийсэнтэй холбоотой байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 9,385,627.1 мянга, эцсийн үлдэгдэл 11,245,946.3 мянган төгрөг болж, 1,860,319.2 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт №7. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 320,944.7 | 320,944.7 | - | 2.9 |
| Хуримтлагдсан үр дүн | 8,845,227.7 | 10,705,546.9 | 1,860,319.2 | 95.2 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 219,454.7 | 219,454.7 | - | 2.0 |
| **Дүн** | **9,385,627.1** | **11,245,946.3** | **1,860,319.2** | **100** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 11,245,946.3 мянган төгрөг болж 1,860,319.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,853,222.1 мянган төгрөг, өмнөх оны илүү олгосон, тэтгэвэр тэтгэмжийн 7,097.1 мянган төгрөгийг буцаан төлүүлж өмнөх үеийн үр дүнг бууруулсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Сангийн орлого бүрдүүлэлт

НДЕГ-ын даргын 2021.12.27-ны өдрийн А/175 тоот тушаалаар 2021 оны төсвийн хуваарь өөрчлөлт оруулж, санд 21,118,441.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр сангийн орлогын төлөвлөгөөг сан тус дээр давуулан нийт орлогыг 117.1 хувиар давуулан биелүүлж, 24,738,927.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хавсралт №8. Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

| № | Сангийн төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 18,571,028.80 | 21,295,695.97 | 2,724,667.2 | 114.7 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 1,479,272.70 | 1,912,314.55 | 433,041.8 | 129.3 |
| 3 | ҮОМШӨД-ын сан | 767,916.80 | 1,192,005.33 | 424,088.5 | 155.2 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 300,222.70 | 338,911.79 | 38,689.1 | 112.9 |
| | ДҮН | **21,118,441.00** | **24,738,927.64** | **3,620,486.6** | **117.1** |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Харилцах дансны чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд жилийн 5.5 хувийн хүүтэй хадгалуулах гэрээг арилжааны банкнуудтай байгуулж, 2021 онд 8,166.3 мянган төгрөгийн хүүгийн орлого орсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

*Хавсралт №9. Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

| № | Банкны нэр | Жилийн хүү /хувиар/ | Нийт хүүгийн орлого |
|---|---|---|---|
| 1 | Голомт банк | 5.5% | 268.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | ХААН банк | 5.5% | 3987.0 |
| **3** | Төрийн банк | 5.5% | 3910.8 |
| | **ДҮН** | | **8,166.3** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 22,268,973.8 мянга, нийт зарлагыг 73,022,399.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс орлогыг 182,128.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 22,451,102.4 мянган төгрөгөөр, зардлыг 10,328,220.0 мянган төгрөгөөр бууруулж, 62,694,179.9 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр 9 арга хэмжээний зардалд зориулан 61,978,691.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардалд 751,044.8 мянга, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн зардалд 61,227,646.9 мянган төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Тайлант онд НДЕГ-аас тэтгэврийн даатгалын сангийн санхүүжилтээр 36,931.0 мянга, тэтгэмжийн даатгалын сангийн санхүүжилтээр 1,010,000.0 мянга, ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүжилтээр 251,000.0 мянга, нийт 38,191,990.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, улсын төсвөөс 43,992.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн даатгалын сангийн орлогоор 27,742,858.7 мянга, бусад орлогоор 17,361.1 мянга, нийт 27,760,219.8 мянган төгрөгийн орлого оруулж, 60,090,767.5 мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн зардалд, сувилал унааны зардалд 87.2 мянга, банкны үйлчилгээний хөлсөнд 6,298.1 мянга, тэтгэврийн даатгалын санд 89,504.1 мянга төгрөг олгосон байна.

*Хавсралт 10. Сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл / мянган төгрөгөөр/*

| № | Сангийн төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Даатгуулагчийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | Тэтгэврийн даатгалын сан | 57,820,355.90 | 56,778,643.52 | 1,041,712.4 | 98.2 | 10,318.0 |
| **2** | Тэтгэмжийн даатгалын сан | 2,673,163.30 | 2,609,008.11 | 64,155.2 | 97.6 | 2563 |
| **3** | ҮОМШӨД-ын сан | 154,879.40 | 159,925.44 | (5,046.0) | 103.3 | 31 |
| **4** | Ажилгүйдлийн даатгалын сан | 579,248.30 | 639,079.89 | (59,831.6) | 110.3 | 464 |
| | ДҮН | **61,227,646.90** | **60,186,656.97** | **1,040,989.9** | **98.3** | **13,376.0** |

*Эх сурвалж: :Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

ҮОМШӨД-ын сангийн батлагдсан зардлыг 5,046.0 мянга, ажилгүйдлийн даатгалын сангийн зардлыг 59,831.6 мянган төгрөгөөр хэтрүүлж, дутагдсан эх үүсвэрийг тэтгэврийн даатгалын сангаас зарцуулсан бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 -т заасны дагуу тэтгэвэр, тэтгэмжийг олгосонтой холбоотой байна.

Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс өөрийн орлогын төлөвлөгөөгүй ажилладаг бөгөөд НДЕГ-аас хэлтсийн үйл ажиллагаанд 751,044.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 749,457.5 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 4,823.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 285.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор Н.Бүнчинсүрэн нар санхүүгийн тайлангийн аудит хийсэн байна.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээлэл, тайлант онд олгосон тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтыг программ, харилцахын дүнгээр түүвэрлэн шалгасан ба олголт тус бүрээр хувийн хэргийг нэг бүрчлэн шалгаагүй болно.

Тус байгууллагын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын магадлагч их эмчийг тус байгууллагын даргын 2021 оны Б/30 дугаар тушаалаар “тус ажилтан нь 2020 оны 10 дугаар сард докторантын сургалтад хамрагдахаар чөлөө авч Улаанбаатар хот руу яваад хүндэтгэн үзэх шалтгаангүй ажлын байрандаа ирж ажиллаагүй...” гэсэн үндэслэлээр ажлаас чөлөөлсөн боловч 2021 оны 01-09 дүгээр сарын цалинг бүтэн бодож олгосон байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 8 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд тус байгууллага нь тэтгэврийн даатгалын сангаас давхардсан тоогоор 13817 иргэнд 56,772,350.8 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 2563 иргэнд 2,528,521.4 мянган төгрөгийн тэтгэмж, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 31 иргэнд 150,815.4 мянган төгрөгийн тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангаас 464 иргэнд 639,079.9 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

ҮОМШӨД-ын сангийн батлагдсан зардлыг 5,046.0 мянга, ажилгүйдлийн даатгалын сангийн зардлыг 59,831.6 мянган төгрөгөөр хэтрүүлж, дутагдсан эх үүсвэрийг тэтгэврийн даатгалын сангаас зарцуулсан бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 -т заасны дагуу тэтгэвэр, тэтгэмжийг олгосонтой холбоотой байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст 899,567.1 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой 40,835.8 мянган төгрөгийн 2 мэдээлэл, таван сая төгрөгийн дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 51,747.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ мэдээлээгүй, 107,686.6 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

**Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Тус байгууллагын үйл ажиллагааны төсвийг зарцуулахдаа дээрх тогтоолыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 753,684.8 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 2,640.0 мянган төгрөг нэмж 751,044.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 749,457.5 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 0.2 хувийн хэмнэлт гаргасан.

- Бичиг хэргийн зардлыг 8,425.7 мянган төгрөгөөр баталсныг бүрэн зарцуулсан байна.

-Албан томилолтын зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 1,919.0 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан төсөвт 4.1 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 38,100.0 мянган төгрөгөөр баталж тодотголоор 2,350.8 мянган төгрөг хасаж 35,749.2 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 35,656.2 мянган төгрөг зарцуулсан нь анх баталсан дүнгээс 2,443.7 мянган төгрөг буюу 6.4 хувь хэмнэсэн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,287.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,734.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5,553.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 05 дугаартай захирамжаар Л.Мөнхцацралд ажилгүй байх хугацааны цалин 3,237.5 мянган төгрөгийг олгуулахаар шийдвэрлэсний дагуу 2016 оны 09 дүгээр сард Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн төсвөөс олгосон

зөрчлийг арилгах албан шаардлагыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудит, мониторингийн газрын дарга Б.Ганхуягт энэ тайлангийн хавсралтаар хүргүүлсэн тул биелэлтийг хянах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7402.3 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 4,250.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 3,152.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

1. Тайланд хугацаанд урсгал засварын зардлаас 2750.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан ч барилгын засварын материалын дансанд бүртгэж зарцуулсан, 1500.0 мянган төгрөгийн үнэ бүхий проекторын дэлгэц, агаар цэвэршүүлэгч зэргийг сэлбэг хэрэгслийн дансанд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дансанд залруулав.

### 4.2 Зөвлөмж

1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдад олгосон 2,657.0 мянган төгрөгийн дархлаа дэмжих бүтээгдэхүүн, ЭХМК-ийн үйл ажиллагаанд зарцуулсан 495.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал нийт 3,152.3 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд орлого аваагүй, шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

2. Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудаст 899,567.1 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой 40,835.8 мянган төгрөгийн 2 мэдээлэл, таван сая төгрөгийн дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 51,747.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ мэдээлээгүй, 107,686.6 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4 дэх “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй мэдээллийг аудитын явцад мэдээлж залруулсан ба цаашид Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч, албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалтыг 12 дугаар сард зохион байгуулж сургалтын хоол бичиг хэргийн зардалд 1,789.7 мянга, томилолтын зардалд 1,919.0 мянган төгрөг зарцуулсан, мөн Засгийн газрын тогтоолоор нийт батлагдсан төсөвт 10-аас доошгүй, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20-оос доошгүй хувиар даалгасан байхад тус байгууллага нь нийт батлагдсан 753,684.8 мянган төгрөгийн төсөвт 0.2 хувийн хэмнэлт гаргасан, үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6.4 хувь хэмнэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.5 дахь “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх”, 1.1 дэх “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.8 дахь “байгууллагын цахилгаа, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-оос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | БНА-2022/21/НА-СТА-ТТ3 | Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдад олгосон 2657.0 мянган төгрөгийн дархлаа дэмжих бүтээгдэхүүн, ЭХМК-ийн үйл ажиллагаанд зарцуулсан 495.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал нийт 3152.3 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд орлого аваагүй, шууд зардлаар бүртгэсэн байна. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв | 1 | 3152.3 | | | | | | | | | 1 | 3152.3 |
| 2 | Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | БНА-2022/21/НА-СТА-ТТ3 | Тайланд хугацаанд урсгал засварын зардлаас 2750.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан ч барилгын засварын материалын дансанд бүртгэж зарцуулсан, 1500.0 мянган төгрөгийн үнэ бүхий проекторын дэлгэц, агаар цэвэршүүлэгч зэргийг сэлбэг хэрэгслийн дансанд бүртгэсэн. | Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дансанд залруулав. | 1 | 4250.0 | 1 | 4250.0 | | | | | | | | |
| ДҮН | | | | | 2 | 7402.3 | | | | | | | | | | |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | БНА-2022/21/НА-СТА-ТТ3 | Шилэн дансны цахим хуудаст 899567.1 мянган төгрөгийн 151 мэдээлэл оруулахаас таван сая төгрөгөөс дээш | Шилэн дансны цахим хуудаст мэдээлэлгүй мэдээллийг аудитын явцад мэдээлж залруулсан ба | 1 | - | | | | | | | | | 1 | - |

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой 40835.8 мянган төгрөгийн 2 мэдээлэл, таван сая төгрөгийн дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 51747.7 мянган төгрөгийн 3 гүйлгээ мэдээлээгүй, 107686.6 мянган төгрөгийн 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | цаашид Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. | | | | | | | | | | | | |
| 4 | Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс | БНА-2022/21/НА-СТА-ТТ3 | Төсвийн захирагч нарт Засгийн газрын тогтоолоор нийт батлагдсан төсөвт 10-аас доошгүй, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20-оос доошгүй, бичиг хэргийн зардлыг бууруулахыг даалгасан байхад тус байгууллага нь нийт батлагдсан 753,684.8 мянган төгрөгийн төсөвт 0.2 хувийн хэмнэлт гаргасан, үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6.4 хувь хэмнэсэн байна. | Цаашид Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв. | 1 | - | | | | | | | | | 1 | - |
| | | | | | 4 | 7402.3 | 1 | 4250.0 | | | | | | | 3 | 3152.3 |
| | **ДҮН** | | | | | | | | | | | | | | | |
| **НИЙТ ДҮН** | | | | | | | | | | | | | | | | |

______oOo______